ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудитын тайлан

**Аудитын код:** ДГА-2023/44/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn
Дорноговь аймаг
2023 он


Дарга, тэргүүлэх аудитор: Т.Ган-Өлзий
Утас: 70522734 Цахим хаяг: dornogovi@audit.gov.mn
Аудитын менежер: У.Оюунтүлхүүр
Утас: 70523020 Цахим хаяг: oyuntulkhuur.u@audit.gov.mn

Аудитор: Б.Ариунбаатар
Цахим хаяг: Ariunbaatarb@audit.gov.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

## Агуулга

1.Хараат бус аудиторын дүгнэлт ........ 2
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл ........ 4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА ........ 12
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа ........ 12
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин ........ 12
Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин: ........ 12
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал ........ 13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд ........ 13
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв ........ 14
4.1 Ерөнхий зүйл ........ 15
4.2 Материаллаг байдал ........ 15
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт ........ 16
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал ........ 16
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт ........ 16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал ........ 16
5.Аудитын илрүүлэлт ........ 16
5.1 Залруулсан алдаа ........ 17
5.2 Албан шаардлага ........ 17
5.3 Зөвлөмж ........ 17
6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл ........ 19

### Товчилсон үгийн жагсаалт

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ТӨБЗГ | Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| ҮОМШӨ | Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчин |

ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

Орон нутгийн өмчийн III байр, Залуучууд гудамж,
3 дугаар баг, Сайншанд сум, Дорноговь аймаг, 44103,
Утас: (705) 2-27-34
Цахим хуудас: dornogovi@audit.gov.mn

2023.02.20 № 1-6/85

танай______________-ны №_______________-т

ДОРНОГОВЬ АЙМГИЙН
ЭРҮҮЛ МЭНДИЙН ГАЗРЫН
ДАРГА Г.ЭНХЦЭЦЭГ ТАНАА

**Өөрчлөлтгүй дүгнэлт**

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

**Дүгнэлтийн үндэслэл**

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

**Асуудлыг онцолсон хэсэг**

Тайлант онд тус байгууллагын үйл ажиллагаанд асуудлын онцлох хэсэгт дурдах асуудал илрээгүй болно.

**Аудитын гол асуудал**

Тус байгууллага нь бичиг хэргийн зардлаас улсын тэмдэгтийн хураамж, программын үнэ, принтер засварын хөлсийг, шуудан холбооны зардлаас программын үнэ, шатахуун худалдан авч, БГАҮТХ-ын зардлаас программын хангамжийн зардлыг санхүүжүүлж нийт 4,180,500 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "*Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна*" гэж заасантай нийцэхгүй байна.

**Бусад асуудлын хэсэг**

АДБОУС 2706.10-д зааснаар хууль тогтоомжоор хориглоогүй, аудитын тайланд заавал мэдээлэх аудитын гол асуудал гэж тодорхойлоогүй, тухайлбал аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй байдал үүсээгүй байна.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

0100[illegible]

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Т.ГАН-ӨЛЗИЙ

## 2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

### Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|---|
| 1 | **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **752,081,161.26** | **857,900,317.79** |
| 33 | **АВЛАГА** | 6,025,966.00 | 969,241.19 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | 5,494,676.00 | 00.00 |
| 335 | **Бусад авлага** | 531,290.00 | 969,241.19 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 387,290.00 | 969,241.19 |
| 3352 | Хувь хүмүүсээс авах авлага | 144,000.00 | 00.00 |
| 35 | **БАРАА МАТЕРИАЛ** | 746,055,195.26 | 856,931,076.60 |
| 351 | **Түүхий эд материал** | 655,740,669.33 | 755,990,892.64 |
| 35110 | Тусгай зориулалттай материал | 210,267,128.55 | 182,068,132.80 |
| 35130 | Эм боох материал | 445,473,540.78 | 573,922,759.84 |
| 354 | **Хангамжийн материал** | 90,314,525.93 | 100,940,183.96 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 4,571,390.00 | 7,662,917.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 29,015,230.48 | 43,883,308.20 |
| 35430 | Сэлбэг хэрэгсэл | 3,563,990.00 | 3,728,990.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 15,451,136.71 | 6,508,905.71 |
| 35450 | Барилгын засварын материал | 9,946,350.00 | 492,800.00 |
| 35470 | Бусад хангамжийн материал | 27,766,428.74 | 38,663,263.05 |
| 2 | **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **897,215,163.70** | **868,478,945.04** |
| 39 | **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | 897,215,163.70 | 868,478,945.04 |
| 392 | **Биет хөрөнгө** | 871,871,163.70 | 843,134,945.04 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 807,890,470.58 | 807,890,470.58 |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | -46,358,556.44 | -63,359,344.40 |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 140,471,297.00 | 140,471,297.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | -79,571,297.00 | -90,071,297.00 |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 157,275,695.20 | 180,352,887.20 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | -118,695,935.06 | -137,990,606.89 |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 50,292,342.99 | 53,314,342.99 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | -39,443,519.91 | -47,477,304.44 |
| 39214 | Бусад үндсэн хөрөнгө | 690,300.00 | 690,300.00 |
| 39215 | Хуримтлагдсан элэгдэл | -679,633.66 | -685,800.00 |
| 393 | **Биет бус хөрөнгө** | 25,344,000.00 | 25,344,000.00 |
| 39301 | Програм хангамж | 785,000.00 | 785,000.00 |
| 39302 | Хуримтлагдсан элэгдэл | -785,000.00 | -785,000.00 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 25,344,000.00 | 25,344,000.00 |
| 3 | **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **1,649,296,324.96** | **1,726,379,262.83** |
| 4 | **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **7,828,795.50** | **00.00** |
| 413 | **Өглөг** | 7,828,795.50 | 00.00 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | 7,539,967.50 | 00.00 |
| 41320 | Бараа үйлчилгээний зардлын өглөг | 8,780.00 | 00.00 |
| 4136 | **Бусад өглөг** | 280,048.00 | 00.00 |
| 41361 | Байгууллагад төлөх өглөг | 280,048.00 | 00.00 |
| 5 | **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **1,641,467,529.46** | **1,726,379,262.83** |
| 51 | **Засгийн газрын хувь оролцоо** | 1,641,467,529.46 | 1,726,379,262.83 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 831,604,364.82 | 831,604,364.82 |
| 51101 | Өмч: - төрийн | 831,604,364.82 | 831,604,364.82 |
| 512 | **Хуримтлагдсан үр дүн** | 634,371,400.34 | 719,283,133.71 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 634,371,400.34 | 634,371,400.34 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 84,911,733.37 |
| 51300 | Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 175,491,764.30 | 175,491,764.30 |
| 6 | **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **1,649,296,324.96** | **1,726,379,262.83** |

ЕЮА0056 9025707

### Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|

| | | | |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **10,838,995,533.35** | **3,897,262,106.40** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **6,925,334,286.34** | **2,051,381,278.40** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | 6,925,334,286.34 | 2,051,381,278.40 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 00.00 | 20,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 00.00 | 20,000.00 |
| 120017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Үндсэн хөрөнгө | 65,038,377.00 | 19,187,192.00 |
| 120018 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-Бараа материал | 6,860,295,909.34 | 2,032,174,086.40 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,913,661,247.01** | **1,845,880,828.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,664,872,600.00 | 1,635,940,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,664,872,600.00 | 1,635,940,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,248,788,647.01 | 209,940,228.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 140,499,400.01 | 127,070,270.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 319,641,634.40 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,198,902,200.00 | 37,315,716.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 589,745,412.60 | 45,554,242.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **10,349,148,158.21** | **3,812,350,373.03** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **10,349,148,158.21** | **3,812,350,373.03** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 8,250,508,651.03 | 2,782,658,581.83 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 486,419,664.46 | 430,387,307.00 |
| 210101 | Үндсэн цалин | 257,508,801.47 | 305,960,012.81 |
| 210102 | Нэмэгдэл | 166,373,680.56 | 58,528,936.24 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 30,389,857.25 | 27,995,000.00 |
| 210104 | Урамшуулал | 32,147,325.18 | 37,903,357.95 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 66,921,863.42 | 53,436,830.02 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 48,849,584.69 | 37,469,516.49 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,673,651.47 | 4,438,426.68 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,641,481.28 | 3,322,261.36 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 852,579.60 | 766,522.99 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,904,566.38 | 7,440,102.50 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,262,555.17 | 40,539,231.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,954,375.17 | 4,155,738.08 |
| 210302 | Түлш, халаалт | 30,296,960.00 | 31,290,875.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,011,220.00 | 5,092,618.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 184,652,019.06 | 108,015,737.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 17,705,771.00 | 16,018,137.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 48,179,557.00 | 53,889,493.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,377,500.00 | 8,076,636.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 403,968.00 | 240,452.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 108,322,096.60 | 29,791,019.00 |
| 210408 | Бараа материал актласны зардал | 7,663,126.46 | 00.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 6,823,858,714.65 | 1,882,006,776.66 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 6,823,858,714.65 | 1,881,886,776.66 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 120,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 224,800,123.26 | 39,992,801.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 205,198,983.26 | 38,675,476.00 |
| 210604 | Урсгал засвар | 19,601,140.00 | 1,317,325.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 118,226,600.00 | 76,420,200.00 |
| 210701 | Гадаад албан томилолт | 00.00 | 67,000.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 118,226,600.00 | 76,353,200.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 259,001,132.00 | 60,121,038.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 248,415,458.34 | 56,613,294.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 977,850.00 | 977,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 152,286.00 | 13,528.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 9,360,849.66 | 2,464,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,688.00 | 52,366.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 46,365,979.01 | 91,738,660.66 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 7,427,486.00 | 7,230,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 180,000.00 | 29,673,050.00 |

| | | | |
|---|---|---|---|
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 38,758,493.01 | 54,835,410.66 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 2,098,639,507.18 | 1,029,691,791.20 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,060,040,193.00 | 1,000,644,006.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 128,433,431.00 | 296,757,706.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 839,415,356.00 | 703,328,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,092,191,406.00 | 558,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 38,599,314.18 | 29,047,785.20 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 38,599,314.18 | 29,047,785.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **489,847,375.14** | **84,911,733.37** |
| **225** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН** | 178,114.61 | 00.00 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 178,114.61 | 00.00 |
| **4** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)** | -178,114.61 | 00.00 |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **489,669,260.53** | **84,911,733.37** |

## Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | | |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **3,913,661,247.01** | **1,851,878,504.00** |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **3,913,661,247.01** | **1,851,878,504.00** |
| **1310** | **Улсын төвлөрсөн төсвөөс** | 1,664,872,600.00 | 1,635,940,600.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 1,664,872,600.00 | 1,635,940,600.00 |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | 2,248,788,647.01 | 215,937,904.00 |
| 131101 | Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж | 140,499,400.01 | 127,070,270.00 |
| 131103 | ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 319,641,634.40 | 00.00 |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 1,198,902,200.00 | 42,810,392.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 589,745,412.60 | 46,057,242.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **3,912,556,247.01** | **1,844,966,504.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **3,912,556,247.01** | **1,844,966,504.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,808,728,663.83** | **816,065,712.80** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 458,005,500.00 | 437,902,442.81 |
| 210101 | Үндсэн цалин | 254,558,383.90 | 310,335,722.65 |
| 210102 | Нэмэгдэл | 144,240,249.87 | 62,711,061.74 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 29,946,393.15 | 27,348,269.53 |
| 210104 | Урамшуулал | 29,260,473.08 | 37,507,388.89 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 55,823,200.00 | 53,791,102.90 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 39,283,000.00 | 37,673,910.31 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,135,100.00 | 4,063,205.67 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,308,000.00 | 3,234,184.57 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 827,000.00 | 799,189.58 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,270,100.00 | 8,020,612.77 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 40,262,555.17 | 40,539,231.08 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 4,954,375.17 | 4,155,738.08 |
| 210302 | Түлш, халаалт | 30,296,960.00 | 31,290,875.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 5,011,220.00 | 5,092,618.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 68,547,429.00 | 74,194,166.41 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,632,400.00 | 16,989,495.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 46,970,645.00 | 39,867,852.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 2,545,500.00 | 12,862,636.41 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 1,000,000.00 | 240,000.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,398,884.00 | 4,234,183.00 |
| **2105** | **Нормативт зардал** | 714,099,000.00 | 5,026,782.60 |

4417144353

| | | | |
|---|---|---|---|
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 714,099,000.00 | 2,614,282.60 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 00.00 | 2,412,500.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 37,561,990.00 | 9,478,518.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 2,070,000.00 | 198,000.00 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 2,708,400.00 | 2,398,910.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,783,590.00 | 6,881,608.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 118,077,960.00 | 77,206,800.00 |
| 210702 | Дотоод албан томилолт | 118,077,960.00 | 77,206,800.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 294,371,164.66 | 66,659,461.00 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 285,267,491.00 | 63,052,685.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 977,850.00 | 977,850.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 152,286.00 | 112,560.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 44,000.00 | 00.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 7,878,849.66 | 2,464,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 50,688.00 | 52,366.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21,979,865.00 | 51,267,208.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,791,300.00 | 19,372,200.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,188,565.00 | 31,895,008.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **2,103,827,583.18** | **1,028,900,791.20** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 2,059,733,593.00 | 999,853,006.00 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 163,748,019.00 | 296,757,706.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 804,613,874.00 | 697,537,300.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 1,091,371,700.00 | 5,558,000.00 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | 44,093,990.18 | 29,047,785.20 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 44,093,990.18 | 29,047,785.20 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **1,105,000.00** | **6,912,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | **1,105,000.00** | **6,912,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **1,105,000.00** | **6,912,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | 1,105,000.00 | 6,912,000.00 |
| 225106 | Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал | 1,105,000.00 | 6,912,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-1,105,000.00** | **-6,912,000.00** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | 00.00 | 00.00 |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | 00.00 | 00.00 |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | 00.00 | 00.00 |

**Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан**

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|
| C01 | **2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 831,604,364.82 | 1,937,989.00 | -73,606,661.65 | 759,935,692.17 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **831,604,364.82** | **1,937,989.00** | **-73,606,661.65** | 759,935,692.17 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |

4417144353
ЕЮА0056 0025707

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| C07 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | -23,858,347.01 | -23,858,347.01 |
| C08 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **831,604,364.82** | **175,491,764.30** | **634,371,400.34** | 1,641,467,529.46 |
| D01 | **2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл** | **831,604,364.82** | **175,491,764.30** | **634,371,400.34** | 1,641,467,529.46 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **831,604,364.82** | **175,491,764.30** | **634,371,400.34** | 1,641,467,529.46 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | 00.00 | 00.00 | 00.00 | 00.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | 00.00 | 00.00 | 84,911,733.37 | 84,911,733.37 |
| D09 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **831,604,364.82** | **175,491,764.30** | **719,283,133.71** | 1,726,379,262.83 |

**Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан**

**/ төгрөгөөр /**

| **Эдийн засгийн ангилал** | **Үзүүлэлт** | **Тайлант оны** | | | |
|---|---|---|---|---|---|
| | | **Батлагдсан төлөвлөгөө** | **Гүйцэтгэл** | **Зөрүү** | **Хувь** |
| **1** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | | |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | 1,715,948,400.00 | 1,606,892,814.80 | 109,055,585.2 | 93.6 |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | 1,715,948,400.00 | 1,606,892,814.80 | 109,055,585.2 | 93.6 |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | 635,955,800.00 | 612,039,808.80 | 23,915,991.2 | 96.2 |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | 438,858,700.00 | 437,902,442.81 | 956,257.2 | 99.8 |
| 210101 | Үндсэн цалин | 294,033,000.00 | 310,335,722.65 | (16,302,722.7) | 105.5 |
| 210102 | Нэмэгдэл | 66,987,900.00 | 62,711,061.74 | 4,276,838.26 | 93.6 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 34,650,000.00 | 27,348,269.53 | 7,301,730.47 | 78.9 |
| 210104 | Урамшуулал | 43,187,800.00 | 37,507,388.89 | 5,680,411.11 | 86.8 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | 58,328,000.00 | 53,791,102.90 | 4,536,897.10 | 92.2 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,045,600.00 | 37,673,910.31 | 3,371,689.69 | 91.8 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,320,600.00 | 4,063,205.67 | 257,394.33 | 94.0 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 3,456,500.00 | 3,234,184.57 | 222,315.43 | 93.6 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 864,100.00 | 799,189.58 | 64,910.42 | 92.5 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 8,641,200.00 | 8,020,612.77 | 620,587.23 | 92.8 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | 54,477,300.00 | 40,539,231.08 | 13,938,068.92 | 74.4 |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 9,863,300.00 | 4,155,738.08 | 5,707,561.92 | 42.1 |
| 210302 | Түлш, халаалт | 29,991,400.00 | 31,290,875.00 | (1,299,475.00) | 104.3 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 14,622,600.00 | 5,092,618.00 | 9,529,982.00 | 34.8 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | 28,670,700.00 | 28,670,699.41 | 0.59 | 100.0 |
| 210401 | Бичиг хэрэг | 3,336,700.00 | 6,557,375.00 | (3,220,675.00) | 196.5 |

4417144353

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 210402 | Тээвэр, шатахуун | 14,505,600.00 | 7,323,105.00 | 7,182,495.00 | 50.5 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 7,883,700.00 | 10,720,636.41 | (2,836,936.41) | 136.0 |
| 210405 | Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал | 953,300.00 | 240,000.00 | 713,300.00 | 25.2 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,991,400.00 | 3,829,583.00 | (1,838,183.00) | 192.3 |
| **2105** | **Нормативт зардал** | 4,795,800.00 | 4,795,782.60 | 17.40 | 100.0 |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | 2,383,300.00 | 2,383,282.60 | 17.40 | 100.0 |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,412,500.00 | 2,412,500.00 | - | 100.0 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | 6,947,400.00 | 6,947,160.00 | 240.00 | 100.0 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 833,300.00 | 833,300.00 | - | 100.0 |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | 902,900.00 | 902,660.00 | 240.00 | 100.0 |
| 210604 | Урсгал засвар | 5,211,200.00 | 5,211,200.00 | - | 100.0 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | 11,719,700.00 | 9,031,000.00 | 2,688,700.00 | 77.1 |
| 210702 | Дотоод албан томилолт | 11,719,700.00 | 9,031,000.00 | 2,688,700.00 | 77.1 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | 10,628,100.00 | 8,900,432.00 | 1,727,668.00 | 83.7 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 6,703,900.00 | 5,293,656.00 | 1,410,244.00 | 79.0 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,000,000.00 | 977,850.00 | 22,150.00 | 97.8 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 160,000.00 | 112,560.00 | 47,440.00 | 70.4 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношилгоо | 50,000.00 | 00.00 | 50,000.00 | - |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 2,633,200.00 | 2,464,000.00 | 169,200.00 | 93.6 |
| 210807 | Газрын төлбөр | 81,000.00 | 52,366.00 | 28,634.00 | 64.6 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | 21530100.00 | 21461958.00 | 68,142.00 | 99.7 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 19,439,800.00 | 19,372,200.00 | 67,600.00 | 99.7 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,090,300.00 | 2,089,758.00 | 542.00 | 100.0 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | 1079992600.00 | 994853006.00 | 85,139,594.00 | 92.1 |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | 1,079,992,600.00 | 994,853,006.00 | 85,139,594.00 | 92.1 |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 284,624,800.00 | 296,757,706.00 | (12,132,906.0) | 104.3 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 794,809,800.00 | 697,537,300.00 | 97,272,500.00 | 87.8 |

4417144353
ЕЮА0056 9025707

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 558,000.00 | 558,000.00 | - | 100.0 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | 1,715,948,400.00 | 1,635,940,600.00 | 80,007,800.00 | 95.3 |
| **1310** | **УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | 1,715,948,400.00 | 1,635,940,600.00 | 80,007,800.00 | 95.3 |
| 131001 | Улсын төсвөөс санхүүжих | 1,715,948,400.00 | 1,635,940,600.00 | 80,007,800.00 | 95.3 |
| **62** | **АЖИЛЛАГСДЫН ТОО** | 28.00 | 30.00 | (2.00) | 107.1 |
| 620001 | Удирдах ажилтан | 01.00 | 01.00 | - | 100.0 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 23.00 | 24.00 | (1.00) | 104.3 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 03.00 | 05.00 | (2.00) | 166.7 |
| 620004 | Гэрээт ажилтан | 01.00 | 00.00 | 1.00 | - |

**Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан**

/төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх он | Гүйцэтгэл | |
|---|---|---|---|---|
| | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | | | |
| I | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | - | **215,937,904.00** | **(215,937,904.00)** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | - | **215,937,904.00** | **(215,937,904.00)** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | - | 210,937,904.00 | (210,937,904.00) |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | - | 45,588,167.00 | (45,588,167.00) |
| 210401 | Бичиг хэрэг | - | 10,432,120.00 | (10,432,120.00) |
| 210402 | Тээвэр, шатахуун | - | 32,544,747.00 | (32,544,747.00) |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | - | 2,142,000.00 | (2,142,000.00) |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | - | 469,300.00 | (469,300.00) |
| **2105** | **Нормативт зардал** | - | 231,000.00 | (231,000.00) |
| 210501 | Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл | - | 231,000.00 | (231,000.00) |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | - | 9,378,658.00 | (9,378,658.00) |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 3,190,000.00 | (3,190,000.00) |
| 210602 | Тавилга | - | 3,022,000.00 | (3,022,000.00) |
| 210603 | Хөдөлмөр хамгааллын хэрэглэл | - | 1,496,250.00 | (1,496,250.00) |
| 210604 | Урсгал засвар | - | 1,670,408.00 | (1,670,408.00) |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | - | 68,175,800.00 | (68,175,800.00) |
| 210702 | Дотоод албан томилолт | - | 68,175,800.00 | (68,175,800.00) |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | - | 57,759,029.00 | (57,759,029.00) |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | - | 57,759,029.00 | (57,759,029.00) |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | - | 29,805,250.00 | (29,805,250.00) |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | - | 29,805,250.00 | (29,805,250.00) |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | - | 5,000,000.00 | (5,000,000.00) |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | - | 5,000,000.00 | (5,000,000.00) |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | - | 5,000,000.00 | (5,000,000.00) |
| II | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | - | 215,937,904.00 | (215,937,904.00) |

| | | | | |
|---|---|---|---|---|
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | - | 215,937,904.00 | (215,937,904.00) |
| 131101 | Төрийн болон орон нутгийн емчит бус этгээдээс авсан хандив, тусламж | - | 127,070,270.00 | (127,070,270.00) |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | - | 42,810,392.00 | (42,810,392.00) |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | - | 46,057,242.00 | (46,057,242.00) |
| **IV** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)** | - | - | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | - | | - |
| | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | - | - | - |

4417144353
ЕЮА0056 9025707

## 3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

### 3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газар нь Эрүүл мэндийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл бүхий төр хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудын "Хэнийг ч орхигдуулахгүй байх" зарчмыг баримтлан үйл ажиллагааг удирдан чиглүүлэн ажиллаж байна.

Хүн амын дунд зонхилон тохиолдох өвчлөл, нас баралтын шалтгааныг судлах, өвчлөлөөс урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх тогтолцоог бэхжүүлж, орчин үеийн оношилгоо, эмчилгээний технологийг нэвтрүүлж эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулах, эрүүл мэндийг дэмжих, эрүүл аж төрөх мэдлэг дадал төлөвшүүлэх, салбар хоорондын хамтын ажиллагааг уялдуулах зорилгоор Нийгмийн эрүүл мэндийн төвийг аймгийн Эрүүл мэндийн газрын дэргэд байгуулан ажиллуулж, улсын хэмжээнд хэрэгжүүлсэн нийгмийн эрүүл мэндийн үндэсний хөтөлбөрүүдийг хэрэгжүүлсэн бөгөөд 2022 оны байдлаар нийгмийн эрүүл мэндийн орон нутгийн дэд хөтөлбөр, төсөл арга хэмжээ тус бүр 7 хэрэгжүүлж байна

Алсын хараа: Эрүүл мэндийн чанартай, аюулгүй тусламж үйлчилгээг – иргэн бүрд

Эрхэм зорилго: Чадварлаг хүний нөөц, манлайлагч нэгдмэл багийн үйл ажиллагаагаар найрсаг харилцаа, дэвшилтэт технологи бүхий чанартай аюулгүй эрүүл мэндийн тусламж үйлчилгээг жигд хүртээмжтэй хүргэж орон нутгийн хүн амын дундаж наслалтыг нэмэгдүүлнэ.

2022 зорилт:

1. Эрүүл мэндийн салбарын удирдлага, зохион байгуулалт, мэдээллийн технологи мэдээллийн удирдлагын тогтолцоог боловсронгуй болгох, санхүү, хөрөнгө оруулалтыг нэмэгдүүлэх, нөөцийн ашиглалтын үр ашгийг сайжруулах
2. Хүний нөөцийн менежментийг боловсронгуй болгох, хүний нөөцийн хангалт, хөгжил, нийгмийн хамгааллыг сайжруулах
3. Нийгмийн эрүүл мэндийн тусламж үйлчилгээг нэгдсэн удирдлагаар хангах, олон нийт, салбар хоорондын оролцоонд тулгуурлан эрүүл мэндийг дэмжих ажиллагааг өргөжүүлэх
4. Эмнэлгийн тусламж үйлчилгээний чанар хүртээмжийг нэмэгдүүлэх, шинэ технологи, инноваци нэвтрүүлэх

### 3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Байгууллагын үйл ажиллагаа явуулж буй хууль эрх зүйн орчин:

- Төсвийн тухай хууль;
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль;
- Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль;
- Татварын ерөнхий хууль;
- Хувь хүний орлогын албан татварын тухай хууль;
- Нийгмийн даатгалын тухай хууль;
- Төрийн албаны тухай хууль;
- Хөдөлмөрийн тухай хууль;
- Шилэн дансны тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль;
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ, худалдан авах тухай хууль;
- Ахмад настны тухай хууль;

- Нийтээр тэмдэглэх баярын болон тэмдэглэлт өдрүүдийн тухай хууль;
- Эрүүл мэндийн тухай хууль;
- Эрүүл мэндийн даатгалын тухай хууль;

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Санхүүгийн хяналт, дотоод аудитын албанаас 2022 онд хяналт шалгалт хийгдээгүй байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

### 3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг 2018 оны 02 дугаар сарын 20-ны өдөр байгууллагын даргын тушаалаар батлуулсан байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

### 3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан "Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар"-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 56.2 сая төгрөгөөр буюу 3.4 хувиар өссөн байна. Өмнөх оноос материаллаг өөрчлөлт гарсан бараа материал, үндсэн хөрөнгө данс байна.

*Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт*

/мянган төгрөгөөр/

| Үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл | Өөрчлөлт |
|---|---|---|---|
| Б | 1 | 2 | 3=2-1 |
| Мөнгөн хөрөнгө | - | - | - |
| Авлага | 6,026.0 | 969.2 | (5,056.8) |
| Урьдчилгаа | - | - | - |
| Бараа материал | 746,055.2 | 856,931.1 | 110,875.9 |
| Үндсэн хөрөнгө | 897,215.2 | 868,278.9 | (28,736.2) |
| **Нийт хөрөнгө** | **1,649,296.4** | **1,726,379.2** | **77,082.9** |
| Өр төлбөр | 7,828.8 | 0 | (7,828.8) |
| Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/ | 1,641,467.53 | 1,726,379.2 | 84,911.7 |
| **Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн** | **1,649,296.4** | **1,726,379.2** | **77,082.9** |

Дээрх хүснэгтээс харахад, авлага дансны үлдэгдэл 1.0 сая төгрөг болж өмнөх оноос 5.1 сая төгрөгөөр буурсан нь татаас санхүүжилтийн авлага барагдсантай холбоотой байна.

Бараа материал дансны үлдэгдэл 856.9 сая төгрөг болж 110.9 сая төгрөгөөр өссөн нь эм боох материал 128.4 сая төгрөг, бичиг хэргийн материал 3.1 сая төгрөг, аж ахуйн материал 14.9 сая төгрөг, сэлбэг хэрэгсэл 0.2 сая төгрөг, бусад хангамжийн материал 10.9 сая төгрөгөөр тус тус өсөж, тусгай зориулалттай материал 28.2 сая төгрөг, түлш шатах тослох материал 8.9 сая төгрөг, барилгын засварын материал 9.5 сая төгрөгөөр тус тус буурснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 868.3 сая төгрөг болж өмнөх оноос 28.7 сая төгрөгөөр буурсан нь машин тоног төхөөрөмж 23.1 сая төгрөг, тавилга эд хогшил 3.0 сая төгрөгөөр нэмэгдэж, тайлант хугацааны 47.8 сая төгрөгийн элэгдэл хорогдлын дүнгээр буурчээ.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 1,726.4 сая төгрөг болж 84.9 сая төгрөгөөр өссөн нь тайлант оны үр дүн өссөнтэй холбоотой байна.

### 3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

#### 3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,715.9 сая төгрөгөөр, нийт зарлагыг 1,715.9 сая төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

#### 3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,606.9 сая төгрөг буюу 93.6 хувь, 109.1 сая төгрөгийн хэмнэлттэй байгаа нь цалин хөлс, нийгмийн даатгалын шимтгэлийн зардлыг 5.5 сая төгрөгөөр, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 13.9 сая төгрөгөөр, дотоод албан томилолтын зардлыг 2.7 сая төгрөгөөр, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамжийн зардлыг 1.7 сая төгрөгөөр, хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад олгох тэтгэмж 97.3 сая төгрөгөөр дутуу зарцуулсантай холбоотой байна.

*Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл*

/мянган төгрөгөөр/

| д/д | Хөтөлбөр, арга хэмжээ | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Биелэлт, хувиар |
|---|---|---|---|---|---|
| | **Орлого бүрдүүлэлт** | **1,715,948.4** | **1,635,940.6** | **80,007.8** | **95.3%** |
| 1 | Улсын төсвөөс санхүүжих | 1,715,948.4 | 1,635,940.6 | 80,007.8 | 95.3% |
| | **Нийт зардал** | **1,715,948.4** | **1,606,892.8** | **109,055.6** | **109.1%** |
| 1 | Бараа үйлчилгээний бусад зардал | 635,955.8 | 612,039.8 | 23,916.0 | 96.2% |
| 2 | Урсгал шилжүүлэг | 1,079,991.6 | 994,853.0 | 85,139.6 | 92.1% |

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

### 3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т "нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна" гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд тус байгууллагын нэмэлт санхүүжилтийн дансанд нийт 215.9 сая төгрөгийн орлого төвлөрч 215.9 сая төгрөгийн мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдсэн байна.

### 3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тус байгууллагад тайлант онд тусгайлсан төсөл, хөтөлбөр хэрэгжээгүй байна.

## 4.Аудитын тайлан

### 4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д "Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана" гэж заасны дагуу Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг аудитор Б.Ариунбаатар гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор Э.Энхцэцэг, аудитын менежер У.Оюунтүлхүүр, дарга, тэргүүлэх аудитор Т.Ган-Өлзий нар тус тус хэрэгжүүлсэн.

Дорноговь аймгийн Эрүүл мэндийн газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 34 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

### 4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт хөрөнгийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг "дунд" гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны хагас жилийн санхүүгийн тайлангийн нийт хөрөнгийн 1,649.3 сая төгрөгөөс 1 хувиар буюу 16.5 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 70 хувиар буюу 11.5 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж гүйцэтгэлийн материаллаг байдлыг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзлээ.

### 4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага дээд шатны байгууллагаас өгсөн заавар, зөвлөгөөг мөрдөж ажилласан байна.

### 4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

#### 4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тус байгууллага нь тайлант хугацааны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 1,834.9 сая төгрөгийн 31 гүйлгээнээс 664.5 сая төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 965.6 сая төгрөгийн 33 гүйлгээнээс 68.6 сая төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Мөн 2,566.7 сая төгрөгийн 119 тушаал шийдвэр гарсанаас 86.1 сая төгрөгийн 21 тушаалыг байршуулаагүй, 1,322.9 сая төгрөгийн 40 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна.

#### 4.4.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь Шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуульд нийцсэн байна гэж дүгнэлээ.

### 4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

#### 4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудитаар 9 горим сорил хэрэгжүүлсэн.

#### 4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Тус байгууллага нь 2021 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн 2 албан шаардлага, 1 зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлсэн байна.

### 4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар цалин хөлс болон зардлыг зориулалтын дагуу зарцуулж байгаа эсэхийг үзэх шаардлагатай.

## 5.Аудитын илрүүлэлт

Аудитаар илэрсэн нийт зөрчилд 1 албан шаардлага, 2 зөвлөмж өгч, 3 алдааг залруулсан.

### 5.1 Залруулсан алдаа

1. Тус байгууллага нь 2.0 сая төгрөгийн бараа материалын зардлын дансыг буруу сонгож хаасныг залруулсан.
2. Тайлант хугацааны 0.9 сая төгрөгийн авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй орхигдуулсныг залруулав.
3. Тайлант хугацаанд тус байгууллага нь 4 нэр төрлийн 8 ширхэг 4.6 сая төгрөгийн хөрөнгийн үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй байсныг залруулсан.

### 5.2 Албан шаардлага

Цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлын дараалаар эрэмбэлэн харуулав. Үүнд:

**1. Зориулалт бус зарцуулалттай холбоотой асуудал**

Илрүүлэлт:
Тус байгууллага нь бичиг хэргийн зардлаас улсын тэмдэгтийн хураамж, программын үнэ, принтер засварын хөлсийг, шуудан холбооны зардлаас программын үнэ, шатахуун худалдан авч, БГАҮТХ-ын зардлаас программын хангамжийн зардлыг санхүүжүүлж нийт 4,180,500 төгрөгийг зориулалт бусаар зарцуулсан байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д *"Төсвийн шууд захирагч нь батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулна"* гэж заасантай нийцэхгүй байна.

### 5.3 Зөвлөмж

**1. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Илрүүлэлт:
Тус байгууллага нь 2022 оны 3 дугаар сард байгууллагын даргын тушаалаар 790.0 мянган төгрөгийн шатахууныг аялал зугаалгын арга хэмжээнд зарцуулсан байна. Энэ нь Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолын 1.6-д "*Засгийн газрын шийдвэр гарснаас бусад баяр ёслол, тэмдэглэлт ой, урлагийн наадам, спортын уралдаан тэмцээн, салбарын өдөр, аялал зугаалга зэргийг зохион байгуулахгүй байх*" гэж заасантай нийцэхгүй байна.

Үр дагавар:
Төсвийн хөрөнгийг үр ашиггүй зарцуулах

Зөвлөмж:
Байгууллагын хөрөнгөөр аялал зугаалгын арга хэмжээнд дэмжлэг үзүүлэхгүй байх, цаашид Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор ирүүлнэ үү.

**2. Хууль тогтоомжийн хэрэгжилттэй холбоотой асуудал**

Тус байгууллага нь тайлант хугацааны цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын нийт 1,834.9 сая төгрөгийн 31 гүйлгээнээс 664.5 сая төгрөгийн 17 гүйлгээг мэдээлээгүй, зарлагын нийт 965.6 сая төгрөгийн 33 гүйлгээнээс 68.6 сая төгрөгийн 4 гүйлгээг шилэн дансны цахим системд мэдээлээгүй байна. Мөн 2,566.7 сая төгрөгийн 119 тушаал шийдвэр гарсанаас 86.1 сая төгрөгийн 21 тушаалыг байршуулаагүй, 1,322.9 сая төгрөгийн 40 тушаалыг хугацаа хоцроож байршуулсан байна. Энэ нь Шилэн дансны тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3-т *"тогтоосон хугацаанд, тогтмол, шуурхай мэдээлдэг байх"*, 6 дугаар зүйлийн 6.4.5-т *"цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлого, зарлагын мөнгөн гүйлгээг гүйлгээ тус бүрээр, гүйлгээний*

*агуулга, хүлээн авагчийн нэрийг долоо хоногийн дотор мэдээлнэ"* гэж заасныг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Үр дагавар:
Мэдээллийн ил тод байдал алдагдах, хууль, дүрэм, журмын хэрэгжилт хангагдахгүй байх

Өгсөн зөвлөмж:
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн хангаж, өмнөх мэдээллийг нөхөн байршуулах

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2023 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад
талархал илэрхийлье.

## 6.Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Бараа материалын зарлагыг буруу дансанд бүртгэсэн | 1 | 2,024.0 | | | 1 | 2,024.0 | 1 | 2,024.0 | | | | |
| Тайлант хугацааны авлагыг санхүүгийн тайланд тусгаагүй | 1 | 944.2 | 1 | 944.2 | | | | | | | | |
| Үндсэн хөрөнгийн элэгдлийг бодуулаагүй | 1 | 4,617.0 | 1 | 4,617.0 | | | | | | | | |
| **Дүн** | **3** | **7,585.2** | **2** | **5,561.2** | **1** | **2,024.0** | **1** | **2,024.0** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан | 1 | 4,180.5 | - | - | 1 | 4,180.5 | - | - | - | - |
| Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоолыг зөрчсөн | 1 | 790.0 | | | - | - | 1 | 790.0 | | |
| **Дүн** | **2** | **4,970.5** | **-** | **-** | **1** | **4,180.5** | **1** | **790.0** | **-** | **-** |

### Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил | | | | | | | | |
| Шилэн дансны цахим системд мэдээллийг бүрэн байршуулаагүй | 1 | - | - | - | - | - | 1 | - |
| Дүн | **1** | **-** | **-** | **-** | **-** | **-** | **1** | - |
| Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил | | | | | | | | |
| - | - | - | - | - | - | - | - | - |
| Дүн | - | - | - | - | - | - | - | - |
| Нийт дүн | - | - | - | - | - | - | - | - |